

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн Toyota Land Cruiser 78 Petrol (2026) автомашиныг тоноглох ажлын удирдамж

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь Бүгд Найрамдах Солонгос Улсын ХИС-гийн санхүүжилттэй “Алслагдсан нутгийн иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж хүргэх төсөл”-ийг 2026-2027 онд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд хэрэгжүүлж байна. Уг төсөл нь орон нутгийн эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээ, ялангуяа хүүхэд, жирэмсэн эхчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилготой. Энэхүү зорилгын хүрээнд бүрэн тоноглогдсон, туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашин нийлүүлж, эмч, ажилтны чадавхыг бэхжүүлэн, яаралтай тусламжийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах юм.

Зорилго

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн Toyota Land Cruiser 78 (2026) Petrol автомашиныг эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнд ашиглах зориулалтаар тусгайлан тоноглох.

Автомашины үндсэн үзүүлэлт

- **Загвар:** Toyota Land Cruiser 78 Petrol
- **Үйлдвэрлэсэн он:** 2026 /Шинэ/
- **Хөдөлгүүр:** Бензин
- **Хурдны хайрцаг:** Механик
- **Жолооны хүрд:** зүүн

Ажлын хамрах хүрээ: Гүйцэтгэгч нь дээрх автомашинд дараах тоноглол, тоног төхөөрөмжийг аюулгүй, найдвартай суурилуулна.

- Өвчтөн зөөх дамнуурга;
- Хоёр ба түүнээс дээш эмнэлгийн мэргэжилтний суудал;
- Хүчил төрөгч, хяналтын тоног төхөөрөмж, цахилгааны систем;
- Эмнэлгийн хэрэгсэл, тоноглол хадгалах шүүгээ;
- Эмнэлгийн төхөөрөмжүүдийг залган ажиллуулах боломжтой цахилгаан үүсгэвэр.

1. Түргэн тусламжийн кузовын тохижилт

Өвчтөн тээвэрлэх бүхээгийн хана, тааз, шаланд дулаан баригч болон дуу чимээ тусгаарлагч хийж, усны хамгаалалттай шалны хулдаас, таазны зөөлөвч доторлогоо, хана, тааз, хаалга дотор талын өнгө цагаан эсвэл цайвар саарал өнгөтэй. Автомашины дотоод орчинд нийцсэн зориулалтын хуванцар, халалт, дулаанд тэсвэртэй, бөх бат, цэвэрлэхэд хялбар машины дотоод зохион байгуулалтад нийцэх материал ашиглана.			
	Тодорхойлолт	Тоо хэмжээ	Шаардлага
	Эмнэлгийн тасалгааны дулаалга	1 иж бүрдэл	Тааз, хана, шал бүрэн дулаалгатай
	Кабин	1 иж бүрдэл	Жолоочийн кабинтай, аюулгүй байдал, эрүүл ахуй ажлын зайг

			хангахуйц, (урт 550мм өндөр 300мм) багагүй хэмжээтэй гүйдэг цонхтой
	Дуу тусгаарлалт	1 иж бүрдэл	Өндөр чанартай
	Ариутгалд тэсвэртэй доторлогоо	1 иж бүрдэл	Угааж цэвэрлэх боломжтой
	LED дотоод гэрэлтүүлэг	4 ш	Эрчимт гэрэлтүүлэгтэй
	Үзлэгийн гэрэл	1 ш	Тохируулгатай
	Агааржуулалтын систем	1 иж бүрдэл	Бие даасан ажиллагаатай
	Таазны бариул	1 иж бүрдэл	Аюулгүй ажиллагааны

2. Шүүгээ, тавиур

	Тодорхойлолт	Тоо ширхэг	Техникийн шаардлага
1.	Хажуугийн шүүгээ шургуулга	1 иж бүрдэл	- Гүйдэг хаалгатай байх; - Доргионд тэсвэртэй зориулалтын материалаар хийгдсэн, хажуу талын шүүгээ, явган шүүгээг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжүүдийг байрлуулахад тохиромжтой байдлаар угсарч бэхэлсэн галын болон цахилгааны аюулгүй байдлыг хангасан цахилгааны тэжээл, залгуур; - АС/заалны халаагуур, гэрэл зэргийн монтажийг стандартын шаардлагын дагуу холбох.
2.	Тавиур	1 иж бүрдэл	- Доргионд тэсвэртэй зориулалтын материалаар хийгдсэн; - Зай талбайг зөв тооцоолон суурилуулалт хийгдсэн байх.

4. Суудал

	Тодорхойлолт	Тоо хэмжээ	Шаардлага
1.	Эмнэлгийн ажилтны суудал	1 иж бүрдэл	3 цэгийн бүстэй
2.	Ар гэрийн хүний эвхэгддэг суудал	1 иж бүрдэл	Түшлэгтэй, бат бөх

5. Дамнуурга суурилуулалт

	Тодорхойлолт	Тоо хэмжээ	Шаардлага
1.	Үндсэн дугуйт дамнуурга	1 иж бүрдэл	– Даац 150 кг-аас багагүй; – Хөнгөн цагаан хийцтэй; – Машинд түгжигддэг; – Автоматаар эвхэгддэг.
2.	Дамнуурган бэхэлгээний систем	1 иж бүрдэл	
3.	Өвчтөн тогтоох бүс	1 иж бүрдэл	
4.	Дамнуургын зам		

6. Суурилуулах тоног төхөөрөмжүүд

	Тодорхойлолт	Тоо хэмжээ
1.	Амьсгалын замын ба амьсгалуулах тонон төхөөрөмж суурилуулалт	Зөөврийн амьсгалын аппарат 1 иж бүрдэл
		Зөөврийн хүчилтөрөгчийн баллон (редуктор болон урсгал хэмжигчтэй) х 2 иж бүрдэл
		Хананд суурилагдах бобровын аппарат бүхий хүчилтөрөгчийн хийн хангамж х 1 иж бүрдэл
		Яаралтай тусламжийн автомашинд зориулсан гар ажиллагаатай зөөврийн сэхээн амьдруулах төхөөрөмж — насанд хүрэгчид болон хүүхдэд зориулсан силикон АМБУ (гар ажиллагаатай сэхээн амьдруулах амьсгалын уут): тус бүр нэг ширхэг.
		Цахилгаан сорох төхөөрөмж х 1 ширхэг
2.	Хяналтын тоног төхөөрөмж	Зөөврийн олон үйлдэлт дефибриллятор (өвчтөний хяналтын монитор ба зүрхний хэмнэл тогтоогчтой) х 1 иж бүрдэл
		12 сувгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат х 1 ширхэг
3.	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Чичиргээ багатай хэсэгт тавиур эсвэл бэхэлгээ бүхий суурь рам бэлтгэх

7. Цахилгаан нэмэлт үүсгүүр

	Тодорхойлолт	Шаардлага
1.	220V-ын цахилгааны залгуур	1-с доошгүй ширхэг залгууртай байх ба тог өсгөгч, уртасгагч залгуурыг стандартын дагуу угсарч суурилуулан байх, өвчтөн тээвэрлэх бүхээгийн цахилгааны ерөнхий унтраалгыг жолоочийн суудлын ард бэхлэх
2.	12V-ын цахилгааны залгуур	3-с дээш ширхэг залгууртай байх ба өвчтөн тээвэрлэх бүхээгийн цахилгааны унтраалгыг жолоочийн суудлын ард бэхлэх
3.	Eco Flow 1536wh, 1800w багагүй	Шинэ
4.	Автомашины Alternative charger 800W-аас доошгүй	Шинэ
5.	Суурь бэхэлгээ	Зай талбайг зөв тооцоолон суурилуулалт хийгдсэн байх

8. Лого гэрлэн болон дуут дохио

	Тодорхойлолт	Шаардлага
1.	Лого	Захиалагчаас тавигдсан шаардлагын дагуу
2.	Гэрлэн болон дуут дохио	Замын хөдөлгөөний дүрэм, зориулалтын гэрэл болон тусгай дуу дохионы стандартын дагуу

Баталгаат үйлчилгээ

- Тоног төхөөрөмжид 12 сараас доошгүй баталгаат хугацаа олгох;
- Баталгаат хугацаанд үнэ төлбөргүй засвар үйлчилгээ үзүүлэх;
- Суурилуулалт, тохируулга хийх;
- Сэлбэг хэрэгслийн хангалтыг баталгаажуулах.

Ирүүлэх баримт бичиг

- Сонирхлоо илэрхийлсэн албан бичиг;
- Байгууллагын танилцуулга;
- Үнийн санал (татвар, тээвэр суурилуулалт орсон дүнгээр);
- Өмнө гүйцэтгэж байсан ижил төстэй гэрээний мэдээлэл;
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээ;
- Баталгааны бичиг.

Материал хүлээн авах хугацаа

Дээрх материалуудыг битүүмжлэн 2026 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 17:00 цагаас өмнө дараах хаягаар ирүүлнэ үү.

ХАЯГ: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төвийн 4-р давхар. Утас: 329365, 329371